



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/128

Шивээговь сум

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
 тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2020 оны 138 дугаар “Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол” үзэсгэлэн худалдааг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг дарга)

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ш.Буяннэмэх

(Соёлын төвийн Орон нутаг судлах танхимын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Мөнхзаяа

(Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)

3.“Эрүүл хүнс-Эрүүл Монгол” үзэсгэлэн худалдааны удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Үзэсгэлэн худалдааны үйл ажиллагаанд зарцуулагдах 410,000 (дөрвөн зуун арван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), нягтлан бодогч (Б.Түвшинжаргал) нарт зөвшөөрсүгэй.

5.Сумын үзэсгэлэн худалдааг чанартай зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2023 оны 09-р
Сарын 07-ны өдрийн 11/08 тоот
Захирамжийн 1-р хавсралт

Шивээговь суманд “ЭРҮҮЛ ХҮНС – ЭРҮҮЛ МОНГОЛ”

Хөтөлбөрийн хүрээнд үзэсгэлэн худалдаа
зохион байгуулах ажлын удирдамж

2023.09.06

1.Зорилго: 1.1. Шивээговь сумын бизнес эрхлэгчид, малчдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэх, өөр хоорондоо бизнесийн харилцаа тогтоох, хамтран ажиллах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг өргөжүүлэх, “Хүнсний аюулгүй байдал”, Эрүүл хүнс – Эрүүл монгол “ хөтөлбөр, АЗД Сумын засаг дарга гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3.11 тоот заалтын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг дэмжихэд оршино.

2. Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах газар: Шивээговь сумын төв талбайд 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн 11 цагаас 7 хоногын хугацаатай 2023 оны 09 дүгээр сарын 19 ны өдрийн хооронд зохион байгуулна.

3. Зохион байгуулагч: Сумын ЗДТГ, Соёлын төв

4.Оролцох төрөл

- 4.1. Хүнсний ногоо, тэдгээрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн
- 4.2. Хоол үйлдвэрлэл
- 4.3. Гар урлал
- 4.4. Талх нарийн боов
- 4.5. Сүү, цагаан идээ

5. Хүрэх үр дүн: 5.1. Бизнес эрхлэгчид, малчид бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд сурталчлан борлуулж, хамтын ажиллагаа өргөжин, шинэ санал санаачлага бий болгох. Хэрэглэгч худалдан авагчид чанартай хямд бүтээгдэхүүнээр хангах. Орон нутгийн бүтээгдэхүүний чанар, хүртээмж сайжирч нэр төрөл олширч, зах зээлд эрэлт хэрэгцээтэй, өрсөлдөхүйц, чанартай бүтээгдэхүүн бий болгох. Бизнес эрхлэгчид харилцан туршлага солилцох, түншлэл тогтоох, хамтран ажиллах, мэдээлэл бүрдүүлэх орчин бүрдэнэ.

6. Оролцоход тавигдах шаардлага: Үзэсгэлэн худалдаанд оролцох иргэн, аж ахуйн нэгж бүр өөрийн хаяг, самбар танилцуулгатай байна. Дараах шаардлагыг ханган оролцоно.

6.1. Иргэн, аж ахуйн нэгж бүр өөрсдийн сурталчлах

6.2. Борлуулж байгаа бараа бүтээгдэхүүн нь зах зээлийн ханшнаас доогуур байна.

6.3. Баталгаат жин хэмжүүртэй байх, худалдаалж буй бүтээгдэхүүний шаардагд нийцсэн тоног төхөөрөмжтэй байх.

6.4. Хаяг. шошготой байх

6.5. Эрүүл ахуй аюулгүй байдлыг бүрэн хангаж, цэвэр цэмцгэр хувцаслаж, соёлч харилцааг эрхэмлэнэ.

6.6. Галын болон хүнсний аюулгүй ажиллагааг хангасан байх

6.7. Худалдаа хийсэн газрын ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж цэвэр орчин бүрдүүлэх.

7. Шагнал, урамшуулал

7.1. Хүнсний шилдэг бүтээгдэхүүн

7.1.1. Хоол үйлдвэрлэл -1 дүгээр байр -1

7.1.2. Талх, нарын боов -1 дүгээр байр-1

7.1.3. сүү, сүүн бүтээгдэхүүн -1 дүгээр байр -1

7.2. Хөнгөн үйлдвэрлэлийн шилдэг бүтээгдэхүүн

7.2.1. Шилдэг гар урлал -1 дүгээр байр -1

7.3. Газар тариалангийн шилдэг бүтээгдэхүүн

7.3.1. Хамгийн олон төрөл тариалсан -1 дүгээр байр -1

8. Ажлын үр дүн тайлагнах: Үзэсгэлэн худалдааны тайлан мэдээг


2023 оны 09 сарын 20-ны дотор Засаг даргад танилцуулна.

Удирдамж боловсруулсан

ХАА-н тасгийн мэргэжилтэн

Д.Мөнхзаяа

Сумын Засаг даргын 2023 оны 09-р
Сарын 07-ны өдрийн 11/08 тоот
Захирамжийн 2...-р хавсралт



“ЭРҮҮЛ ХҮНС – ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үзэсгэлэн зохион байгуулахад
шаардагдах төсөв

2023.09.06

№	Үйл ажилагаа	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Хоол үйлдвэрлэл	1	50000	50000
2	Талх, нарийн боов	1	50000	50000
3	Сүү цагаан идээ	1	50000	50000
Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн				
4	Шилдэг гар урлал	1	50000	50000
Газар тариалангийн бүтээгдэхүүн				
5	Хамгийн их ургац авсан иргэн	1	50000	50000
6	Өргөмжлөл	5	15000	75000
7	Банер /НӨТ/	2*3м2	15000	100000
8	Эх бэлтгэл	1	10000	10000
9	Нийт төсөв			4350000